

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШИЙДВЭР

 20 ~~22~~ оны 11 сарын ~~17~~ -ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

**“Сэндли ББСБ” ХХК-ийг ХК болгон хэлбэрийг өөрчлөх,  
“Сэндли ББСБ” хувьцаат компанийн дүрмийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.4, 62.1.16 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүн, тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

1. Компани нийт энгийн хувьцааныхаа 29.97 хувийг Монголын хөрөнгийн бирж дээр нээлттэй хүрээнд амжилттай арилжаалсантай холбогдуулан “Сэндли ББСБ” ХХК (хязгаарлагдмал хариуцлагатай компани)-ийг “Сэндли ББСБ” ХК (нээлттэй хувьцаат компани) болгон өөрчилсүгэй.

2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг 3,350,000,000 (Гурван тэрбум гурван зуун тавин сая) төгрөгөөр нэмэгдүүлж, нэг бүр нь 50 (тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 223,570,000 (Хоёр зуун хорин гурван сая таван зуун далан мянга) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 11,178,500,000 (арван нэгэн тэрбум нэг зуун далан найман сая таван зуун мянга) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсныг дурдсугай.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны тоо, эзэмшлийн хувийг дор дурдсанаар баталгаажуулсугай.

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо ширхэг	Нэрлэсэн үнэ	Нийт дүн	Эзэмшлийн хувь
1	“Монголын финтек групп” ХК	126,141,700	50	6,307,085,000	56.42%
2	“Радикс технологи” ХХК	1,714,200	50	85,710,000	0.77%
3	Батдорж Нямжаргал	285,700	50	14,285,000	0.12%
4	Зургаа Цолмон	107,100	50	5,355,000	0.05%
5	Чойжоо Дашсүрэн	71,400	50	3,570,000	0.03%
6	Лхагважав Нарантуяа	71,400	50	3,570,000	0.03%
7	Охиндоо Нямдэлэг	71,400	50	3,570,000	0.03%
8	Ганхуяг Саруул-Од	71,400	50	3,570,000	0.03%
9	Гантөмөр Гантуяа	35,700	50	1,785,000	0.02%
10	“Сэндли эмплөйе” ХХК	20,000,000	50	1,000,000,000	8.95%
11	Баттулга Наранбат	8,000,000	50	400,000,000	3.57%
12	Олон нийт	67,000,000	50	3,350,000,000	29.97%
	Нийт	223,570,000	50	11,178,500,000	100%

4. “Сэндли ББСБ хувьцаат компанийн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

5. Энэхүү тогтоолыг зохих журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, олон нийтэд мэдээлж, холбогдох баримт бичгийг хүргүүлэх, хувьцаат компанийн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Г.Гантуяа/ нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Наранбат/-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НАРАНБАТ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШИЙДВЭР

20 22 оны 11 сарын 17 -ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

### *Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүн, тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгосугай:

1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 1.1.1. Баттулга овогтой Наранбат;
- 1.1.2. Мөнхтөр овогтой Цолмон;
- 1.1.3. Лхагважав овогтой Нарантуяа;
- 1.1.4. Найдан овогтой Билгүүн;
- 1.1.5. Нармандах овогтой Цэвэгмид;
- 1.1.6. Батбаяр овогтой Эрдэнэ.

1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 1.2.1. Баатархүү овогтой Анужин;
- 1.2.2. Батмөнх овогтой Цэлмэг;
- 1.2.3. Цэндсүрэн овогтой Саруултуяа.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.

3. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

4. Компани нээлттэй хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилсөнтэй холбоотойгоор “Сэндли ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгосугай.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний талаарх олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д хүргэхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/ болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Г.Гантуяа/-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.НАРАНБАТ



“Сэндли ББСБ” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус  
хурлын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 02 тоот тогтоолын Хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН  
ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ

ТУЗ-ийн гишүүдийн цалин		ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээ	Хугацаа
Тогтмол цалин	Үндсэн	500,000	Сард нэг удаа олгоно.
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	200,000	
	Хорооны даргын нэмэгдэл	200,000	
Оролцоонд үндэслэсэн цалин	ТУЗ-ийн хуралд оролцсоны нэмэгдэл	250,000	Улиралд нэг удаа олгоно.